



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/112/-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:  
Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар  
Ахлах аудитор Ч.Анхбаяр  
Утас: 8511-6555  
Цахим хаяг: [ankha964@gmail.com](mailto:ankha964@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....</b>	<b>12</b>
5.1 Төлбөрийн акт.....	12
5.2 Албан шаардлага.....	13
5.2 Зөвлөмж.....	13
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>14</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 141.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ЭНХЗАЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант жилийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 113,275.4 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлэхээр төлөвлөж, Сангийн яамны цахим системд нэгтгүүлсэн ба төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ дүнгээр алдаатай тайлагнасан;

ЭМТ-ийн даргын тушаалаар 17,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг албан хаагчдад хавтгайруулан олгосон;

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журам, Сангийн сайдын 1996

оны 63/104 дүгээр тушаалын холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,011,243.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 26,318.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 226,450.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 3,500.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,267,512.8 мянган төгрөгийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,152,407.0 мянган төгрөгийг зарцуулж, төрийн сангийн харилцах дансанд 1,830.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээний хэрэгжилтийг Цэцэрлэг сумын Засаг дарга 96 хувьтай үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>237,129,444.04</u></b>	<b><u>298,340,554.94</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	113,175,476.82	1,830,366.31
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	113,175,476.82	1,830,366.31
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	113,175,476.82	1,830,366.31
31211	Төрийн сангийн харилцах	113,175,476.82	1,830,366.31
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	19,258,721.00	176,877,513.83
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,258,721.00	176,877,513.83
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	104,695,246.22	119,632,674.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	57,375,178.55	58,124,497.13
35130	Эм боох материал	57,375,178.55	58,124,497.13
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	47,320,067.67	61,508,177.67
35410	Бичиг хэргийн материал	339,100.00	468,600.00
35420	Аж ахуйн материал	38,018,347.67	48,877,077.67
35440	Түлш, шатах тослох материал	482,880.00	1,654,130.00
35450	Барилгын засварын материал	7,256,000.00	9,084,800.00
35460	Хүнсний материал	1,223,740.00	1,423,570.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>708,504,992.55</u></b>	<b><u>914,953,644.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	708,504,992.55	914,953,644.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	689,198,992.64	895,727,644.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	639,071,920.00	639,733,636.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85,486,378.44)	(106,173,605.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,840,560.00	141,460,060.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,595,637.00)	(31,201,249.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,109,322.21	231,658,230.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,223,336.07)	(63,738,948.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,617,111.00	100,004,836.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,011,959.41)	(16,592,026.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,952,000.00	3,952,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,154,209.65)	(3,454,889.61)
39217	Ном	79,600.00	79,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,305,999.91	19,225,999.87
39301	Программ хангамж	1,200,000.00	1,200,000.00

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

39302	Хуримтлагдсан элэгдэл	(820,000.09)	(900,000.13)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,926,000.00	18,926,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>945,634,436.59</u></b>	<b><u>1,213,294,198.94</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>754,294,684.09</u></b>	<b><u>1,021,954,446.44</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	754,294,684.09	1,021,954,446.44
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	415,710,459.64	683,558,673.61
51210	Өмнөх үеийн үр дүн	415,710,459.64	415,898,911.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	267,659,762.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	338,584,224.45	338,395,772.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>954,634,436.59</u></b>	<b><u>1,213,294,198.94</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>967,280,755.55</b>	<b>1,470,888,371.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>109,096,713.92</b>	<b>269,200,489.21</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	109,096,713.92	269,200,489.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	836,120.00	3,500,000.00
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	836,120.00	3,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	84,154,417.65	232,180,041.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	24,106,176.27	33,520,447.81
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>858,184,041.63</b>	<b>1,201,687,882.77</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,544,200.00	32,825,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,544,200.00	32,825,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	837,639,841.63	1,168,862,182.77
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	837,639,841.63	1,168,862,182.77
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>871,909,894.04</b>	<b>1,200,563,951.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>871,909,894.04</b>	<b>1,200,563,951.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	871,840,756.46	1,177,056,779.55
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	546,029,198.58	748,334,251.68
210101	Үндсэн цалин	280,576,635.34	425,873,188.32
210102	Нэмэгдэл	184,056,387.53	239,784,412.08
210104	Урамшуулал	49,896,175.71	76,392,651.28

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210105	Гэрээт ажлын хөлс	31,500,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,263,936.90	98,309,376.47
210201	Тэтгэврийн даатгал	47,274,054.23	73,663,499.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,505,181.69	6,161,519.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,400,385.35	3,080,709.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,098,874.05	3,080,709.56
210205	Эрүүл мэндийн даатгал	10,985,441.58	12,322,938.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,500,062.42	23,718,528.19
210301	Гэрэл, цахилгаан	4,354,147.42	4,614,708.19
210302	Түлш, халаалт	16,145,915.00	19,103,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,352,335.70	75,722,011.70
210401	Бичиг хэрэг	3,717,500.00	5,853,100.00
210402	Тээвэр, шатахуун	26,231,990.00	39,510,325.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,695,000.00	6,090,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,496,500.00	1,539,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,114,123.00	10,541,500.00
210408	Бараа материал акталсны зардал	1,097,222.70	12,188,086.70
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	124,988,898.52	142,150,001.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,905,788.52	128,087,731.83
210502	Хоол, хүнс	11,083,110.00	14,062,270.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,871,200.00	13,038,100.00
210604	Урсгал засвар	6,871,200.00	13,038,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,792,000.00	6,989,000.00
210702	Дотоод албан томилолт	5,792,000.00	6,989,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,800,000.00	9,455,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	8,548,112.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	227,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	121,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	58,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	52,243,124.34	59,339,769.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,794,980.70	7,621,038.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,448,143.64	51,718,731.68

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	69,137.58	23,507,171.81
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	69,137.58	6,507,171.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,137.58	6,507,171.81
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>95,370,861.51</u></b>	<b><u>270,324,420.62</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	612,800.40	2,664,658.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	612,800.40	2,664,658.27
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(612,800.40)	(2,664,658.27)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>94,758,061.11</u></b>	<b><u>267,659,762.35</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>839,761,440.63</u></b>	<b><u>1,047,569,089.94</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>836,120.00</b>	<b>3,500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	836,120.00	3,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	836,120.00	3,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	836,120.00	3,500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>838,925,320.63</b>	<b>1,044,069,089.94</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,544,200.00	32,825,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,544,200.00	32,825,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	818,381,120.63	1,011,243,389.94
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	818,381,120.63	1,011,243,389.94
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>814,879,239.68</u></b>	<b><u>1,130,262,200.45</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>814,879,239.68</b>	<b>1,130,262,200.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>814,810,102.10</b>	<b>1,106,755,028.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	546,029,198.58	748,334,251.68
210101	Үндсэн цалин	280,576,635.34	425,873,188.32
210102	Нэмэгдэл	184,056,387.53	239,784,412.08
210104	Урамшуулал	49,896,175.71	76,392,651.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,284,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,500,000.00	-

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,263,936.90	98,309,376.47
210201	Тэтгэврийн даатгал	47,274,054.23	73,663,499.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,505,181.69	6,161,519.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,400,385.35	3,080,709.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,098,874.05	3,080,709.56
210205	Эрүүл мэндийн даатгал	10,985,441.58	12,322,938.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,475,062.42	24,318,528.19
210301	Гэрэл, цахилгаан	4,354,147.42	4,614,708.19
210302	Түлш, халаалт	16,119,900.00	19,703,820.00
210303	Цэвэр, бохир ус	1,015.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,442,360.00	63,427,375.00
210401	Бичиг хэрэг	3,700,000.00	5,525,300.00
210402	Тээвэр, шатахуун	25,452,910.00	39,085,075.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,695,000.00	6,090,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,496,900.00	2,141,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,097,550.00	10,585,300.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	101,999,323.50	121,433,719.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86,690,023.50	99,651,619.30
210502	Хоол, хүнс	10,812,300.00	12,587,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,497,000.00	9,195,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,858,800.00	20,218,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,988,000.00	2,030,000.00
210604	Урсгал засвар	6,870,800.00	18,188,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,792,000.00	6,989,000.00
210702	Дотоод албан томилолт	5,792,000.00	6,989,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,800,000.00	10,955,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	10,048,112.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	227,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	121,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	58,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,149,420.70	12,768,138.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,149,420.70	12,768,138.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,137.58</b>	<b>23,507,171.81</b>

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг		17,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	69,137.58	6,507,171.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,137.58	6,507,171.81
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>24,882,200.95</u></b>	<b><u>(82,693,110.51)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>36,955,000.00</b>	<b>28,652,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>36,955,000.00</b>	<b>28,652,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	36,955,000.00	28,652,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,955,000.00	28,652,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(36,955,000.00)</u></b>	<b><u>(28,652,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(12,072,799.05)	(111,345,110.51)
<b>31</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		113,175,476.82
<b>31</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		1,830,366.31

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D02	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,339,752.50	338,584,224.45	415,710,459.64	945,634,436.59
D03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			188,451.62	188,451.62
D08	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	(188,451.62)		(188,451.62)
D09	Тайлант үеийн үр дүн			267,659,762.35	267,659,762.35
D02	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,339,752.50	338,584,224.45	683,558,673.61	1,213,294,198.94

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьц уулалт
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,322,885,100.00</b>	<b>1,152,407,028.64</b>	<b>170,478,071.36</b>	<b>87.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,322,885,100.00</b>	<b>1,152,407,028.64</b>	<b>170,478,071.36</b>	<b>87.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,292,885,100.00</b>	<b>1,135,407,028.64</b>	<b>157,478,071.36</b>	<b>87.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>775,054,000.00</b>	<b>748,334,251.68</b>	<b>26,719,748.32</b>	<b>96.55</b>
210101	Үндсэн цалин	461,339,000.00	425,873,188.32	35,465,811.68	92.31
210102	Нэмэгдэл	216,293,900.00	239,784,412.08	-23,490,512.08	110.86

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,138,000.00	6,284,000.00	-146,000.00	102.38
210104	Урамшуулал	91,283,100.00	76,392,651.28	14,890,448.72	83.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>107,886,400.00</b>	<b>98,309,376.47</b>	<b>9,577,023.53</b>	<b>91.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,231,000.00	73,663,499.99	6,567,500.01	91.81
210202	Тэтгэмжийн даатгал	6,913,900.00	6,161,519.12	752,380.88	89.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,687,900.00	3,080,709.56	607,190.44	83.54
210204	Ажилгүйдлийн даатгал	3,225,900.00	3,080,709.56	145,190.44	95.50
210205	Эрүүл мэндийн даатгал	13,827,700.00	12,322,938.24	1,504,761.76	89.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,825,700.00</b>	<b>24,318,528.19</b>	<b>6,507,171.81</b>	<b>78.89</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,180,700.00	4,614,708.19	2,565,991.81	64.27
210302	Түлш, халаалт	23,520,000.00	19,703,820.00	3,816,180.00	83.77
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>88,202,100.00</b>	<b>63,427,375.00</b>	<b>24,774,725.00</b>	<b>71.91</b>
210401	Бичиг хэрэг	9,928,700.00	5,525,300.00	4,403,400.00	55.65
210402	Тээвэр, шатахуун	55,800,500.00	39,085,075.00	16,715,425.00	70.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,806,800.00	6,090,000.00	1,716,800.00	78.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	3,016,100.00	2,141,700.00	874,400.00	71.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,650,000.00	10,585,300.00	1,064,700.00	90.86
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>168,531,900.00</b>	<b>121,433,719.30</b>	<b>47,098,180.70</b>	<b>72.05</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,497,000.00	99,651,619.30	32,845,380.70	75.21
210502	Хоол, хүнс	22,634,900.00	12,587,100.00	10,047,800.00	55.61
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,400,000.00	9,195,000.00	4,205,000.00	68.62
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>72,687,600.00</b>	<b>48,870,900.00</b>	<b>23,816,700.00</b>	<b>67.23</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,087,600.00	16,010,000.00	15,077,600.00	51.50
210602	Тавилга	20,000,000.00	14,672,000.00	5,328,000.00	73.36
210604	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00		1,500,000.00	0.00
	Урсгал засвар	20,100,000.00	18,188,900.00	1,911,100.00	90.49
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,697,200.00</b>	<b>6,989,000.00</b>	<b>2,708,200.00</b>	<b>72.07</b>
210702	Дотоод албан томилолт	9,697,200.00	6,989,000.00	2,708,200.00	72.07
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,633,900.00</b>	<b>10,955,740.00</b>	<b>9,678,160.00</b>	<b>53.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,483,900.00	10,048,112.00	8,435,788.00	54.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00	50,000.00	90.91
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	227,700.00	422,300.00	35.03
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	121,928.00	528,072.00	18.76
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	300,000.00	58,000.00	242,000.00	19.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,366,300.00</b>	<b>12,768,138.00</b>	<b>6,598,162.00</b>	<b>65.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,366,300.00	12,768,138.00	6,598,162.00	65.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,000,000.00</b>	<b>17,000,000.00</b>	<b>13,000,000.00</b>	<b>56.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,000,000.00</b>	<b>17,000,000.00</b>	<b>13,000,000.00</b>	<b>56.67</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	17,000,000.00	13,000,000.00	56.67
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,322,885,100.00</b>	<b>1,041,061,918.13</b>	<b>281,823,181.87</b>	<b>78.70</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>32,825,700.00</b>	<b>26,318,528.19</b>	<b>6,507,171.81</b>	<b>80.18</b>
132001	Орон нутгийн төсвөөс	32,825,700.00	26,318,528.19	6,507,171.81	80.18

<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,060,108,500.00</b>	<b>1,011,243,389.94</b>	<b>48,865,110.06</b>	<b>95.39</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,060,108,500.00	1,011,243,389.94	48,865,110.06	<b>95.39</b>
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>229,950,900.00</b>	<b>3,500,000.00</b>	<b>226,450,900.00</b>	<b>1.52</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	3,500,000.00	0.00	<b>100.00</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	226,450,900.00		226,450,900.00	<b>0.00</b>
	Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		113,175,476.82	-113,175,476.82	
	Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,830,366.31	-1,830,366.31	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>100</b>
610001	Төсвийн байгууллага	1	1		100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>30</b>	<b>30</b>		<b>100</b>
620001	Удирдах ажилтан	1	1		100
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19		100
620003	Үйлчлэх ажилтан	10	10		100

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 125,463.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд 12,188.1 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу илэрхийлсэн 113,275.4 мянган төгрөгийн алдаа нь Сангийн яамны цахим системд нэгтгэгдсэн шалтгаанаар залруулагдаагүй болно. Залруулагдаагүй алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа:

- Тайлант онд өмч хамгаалахын шийдвэрээр 31 нэр төрлийн 489 ш 12,188.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, эм боох, бичиг хэргийн материалаас акталсныг тайлант жилийн 210901 бараа үйлчилгээний бусад зардлаар журналын бичилт хийснийг 210408 бараа материал акталсны гарз дансаар залруулан бүртгүүлэв. Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 14.4.2, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар нийт **47,352.0** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, төсөвт төвлөрүүлэх 1,700.0 мянган төгрөг 1 төлбөрийн акт, зөрчил таслан зогсоож, арилгуулах 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг бус зөрчил нь 28,652.0 мянган төгрөг, материаллаг алдааны зөрчил нь 18,700.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **9,259.9** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Албан хаагчдад олгосон 17,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжээс ХХОАТ 10 хувь суутгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1."ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

## 5.2 АЛБАН ШААРДЛАГА

5.2.1 Тайлант жилд ЭМТ-ийн 2024 оны 12 сарын 03 өдрийн Б/33 тоот "Ажилчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай" тушаалаар 17,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" байгууллагын дотоод журамд заасан 4.8, 8.8.4 заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүллээ

5.2.2 Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 45 нэр төрлийн 62 ширхэг 28,921.5 мянган төгрөгийн хөрөнгөнд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүллээ.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд 28,652.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасугай" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой.

Илрүүлэлт:

Тайлант жилийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 113,275.4 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлэхээр төлөвлөж, Сангийн яамны цахим системд нэгтгүүлсэн ба төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ дүнгээр алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг бодит эх үүсвэрээс илүү төлөвлөж Сангийн яаманд нэгтгүүлсэн алдааг давтан гаргахгүй байх, төсвийн төлөвлөлт, тайлагналд тавих хяналтыг сайжруулж, үнэн зөв тайлагнах арга хэмжээ авах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлын ангилал залруулсан	1	12,188.1			1	12,188.1	1	12,188.1				
Мөнгөн хөрөнгийн урьд оны үлдэгдлээс илүү төлөвлөсөн	1	113,275.4			1	113,275.4			1	113,275.4	1	113,275.4
Дүн	2	125,463.5			2	125,463.5	1	12,188.1	1	113,275.4	1	113,275.4

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Нийт зөрчил	Үүнээс
-------------	--------

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон сууцны дэмжлэг олгосон	1	17,000.0			1	17,000.0						
Тэтгэмжээс 10 хувийг суутгаагүй	1	1,700.0	1	1,700.0								
Үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж хугацааг сунгах	1	0			1	0						
Шууд гэрээгээр худалдан авалт хийсэн	1	26,852.0					1	26,852.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>47,352.0</b>	<b>1</b>	<b>1,700.0</b>	<b>2</b>	<b>17,000.0</b>	<b>1</b>	<b>26,852.0</b>				